

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ АЖЛЫН ТАЙЛАН (2024 оны жилийн эцсийн байдлаар)

2024 оны 12 дугаар сарын 27

Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь 2024 оны жилийн эцсийн байдлаар албан бичиг шийдвэрлэлтийг Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” болон холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулж ажиллаж байна.

Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээ

Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт ирсэн бичгийг edoc цахим системд бүртгэн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, шийдвэрлэлтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 1255 албан бичиг ирснийг бүртгэгдсэн байдлаар нь авч үзвэл:


- Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр - 3
- Байгууллагад албан бичгээр ирж бүртгэгдсэн - 567
- Системээр бүртгэгдсэн – 685

Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5,45 хоног байна.

Байгууллагад ирсэн бичгийн шийдвэрлэлт, хаалтын үзүүлэлтийг тоон байдлаар авч үзвэл:

- Хариутай бичиг – 154. Үүнээс хугацаанд нь шийдвэрлэсэн – 143, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн- 9 ба хугацаа сунгуулсан 1, судалж байгаа 2 бичиг байна.
- Хариугүй бичиг: 1101. Үүнээс хугацаанд нь хаасан – 1093, хугацаа хэтэрч хаасан 5, судалж байгаа 3 бичиг байна.

2023, 2024 оны жилийн эцсийн албан бичиг
шийдвэрлэлтийн харьцуулсан график



(график 1)

Өнгөрсөн оны мөн үед ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь 97,47%,

шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног, шийдвэрлэлтийн явцад гарсан зөрчил 25 байсан бол энэ онд бичиг шийдвэрлэлтийн хувь 97,59%, шийдвэрлэлтийн явцад гарсан зөрчил 35, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног байна.

Харилцагч байгууллагуудаас ирсэн бичгийн тоог 2023 оны мөн үеийнхтэй харьцуулбал 30 бичиг буюу 2,33%-иар буурсан.

Албан бичиг шийдвэрлэлтийн явцад илэрсэн зөрчлийн 11 зөрчил буюу 31,42% нь хугацаа хэтэрч шийдвэрлэсэн, 24 зөрчил буюу 68,57% нь явцын тэмдэглэл хугацаанд нь хөтлөөгүй зөрчил байна.

Албан бичиг шийдвэрлэлтийн явцад зөрчил гаргасан албан хаагчид тухай бүрд нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, байгууллагын нийт албан хаагчдад МУ-ын стандарт MNS5140-1:2021, MNS5140-2:2021, MNS5140-3:2021 болон MNS6395:2022 стандартуудыг танилцуулан албан хэрэг хөтлөлтийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах чиглэл өгөн ажиллаж байна.

Явуулсан бичгийн шийдвэрлэлтийн мэдээ


Тус газар нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 965 бичиг боловсруулж явуулснаас стандартын зөрчил 32 тооцогдсон бол 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 1150 албан бичиг боловсруулан, стандартын зөрчил 9 тооцогдож, баримт боловсруулалтын зөрчил 71,87%-иар буурсан.

Явуулсан бичгийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 185 албан бичгээр буюу 19,17% өссөн үзүүлэлтэй байна.

Зөрчлийг тухай бүрт нь албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

Явуулсан бичгийн харьцуулалт:

2023 оны жилийн эцэс		2024 оны жилийн эцэс	
Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	367	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	362
Газар тариалан, мал аж ахуйн хэлтэс	56	Газар тариалан, мал аж ахуйн хэлтэс	82
Мал үржлийн алба	37	Мал үржлийн алба	46
Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс	60	Хүнсний үйлдвэрлэлийн хэлтэс	59
Хяналтын хэлтэс	445	Хяналтын хэлтэс	601
Нийт	965		1150



ХЯНАСАН:
 БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ
 ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.Ичинноров

Б.ИЧИННОРОВ

ТАЙЛАН БИЧСЭН:
 АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
 АЖИЛТАН

Ж.Хандсайхан

Ж.ХАНДСАЙХАН